



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2018 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 40

Номгон

“Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах,
бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах”
журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.2, 77.3 дахь заалт, мөн хуулийн 80 дугаар зүйлийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журам батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Орон нутгийн өмчийн газарт үүрэг болгосугай.

2.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй боловч үндсэн хөрөнгийн шинжийг агуулаагүй, элэгдэл байгуулахад тохиромжгүй хөрөнгийг эргэлтийн хөрөнгийн дансанд шилжүүлэх, эргэлтийн хөрөнгийн данснаас үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэх, үндсэн хөрөнгийн дансны ангилал хооронд шилжүүлэх асуудлыг судлан тухай бүр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралтай зөвшилцсөний үндсэн дээр зөвшөөрөл олгож байх;

2.2. Энэхүү тогтоолыг орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлж, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах саналыг хянаж, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах;

3. Журмыг мөрдөж ажиллахыг сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга нарт зөвлөж, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

5. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

D:/2018/Alban bichig/TH togtool-2018 (Au

0118061

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар сарын
02-ны өдрийн 40 дүгээр тогтоолын хавсралт



**ОРОН НУТГИЙН ӨМЧИД ЭД ХӨРӨНГӨ
ОЛЖ АВАХ, БҮРТГЭХ, ШИЛЖҮҮЛЭХ, АКТАЛЖ
ДАНСНААС ХАСАХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө /цаашид “эд хөрөнгө” гэх/-ийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах тэдгээртэй холбогдон гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлт гүйцэтгэлийг тооцож, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, акталж данснаас хасах тухай саналаа энэ журамд заасны дагуу Орон нутгийн өмчийн газарт ирүүлнэ.

1.3. Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах, данснаас хасах тухай саналыг хянан үзээд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн зохих шийдвэрийг гаргуулж тухайн байгууллагад хүргүүлнэ.

1.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх барих байгууллага болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанаар эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, акталж данснаас хасах тухай асуудлыг хэлэлцэхэд энэхүү журмыг удирдлага болгоно.

1.5. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөл үйл ажиллагаандаа энэхүү журмыг баримтлан ажиллана.

**ХОЁР.ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙН БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ**

2.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь журмын 1.2-т заасан асуудлыг шийдвэрлүүлэхдээ дор дурдсан бичиг баримтаас тухайн харилцаанд хамааралтай баримт материалыг бүрдүүлэн Орон нутгийн өмчийн газарт ирүүлнэ.

2.1.1.Хуулийн этгээдийн эрх барих болон харъяа дээд байгууллагын зөвшөөрөл;

2.1.2.Худалдан авах эх үүсвэр санхүүжилтийг баталсан эрх бүхий байгууллагын шийдвэр, хуваарилагдсан төсөв;

2.1.3 Хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт;

2.1.4. Мэргэжлийн байгууллагын акт, дүгнэлт;

2.1.5.Эдийн засгийн тооцоо, үндэслэл, зах зээлийн үнийн харьцуулсан судалгаа, худалдан авах дээд, доод үнийн санал;

2.1.6. Балансаас балансад шилжүүлэх бол өмч эзэмшигч болон шилжүүлэн авах хуулийн этгээдийн зөвшөөрөл, хүсэлт;

2.1.7.Ашиглалтын хугацаа дуусаагүй, үлдэгдэл өртөгтэй боловч ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн эвдрэл, гэмтлийн шалтгаан болон хуулийн этгээдэд учирсан хохирлын хэмжээг мэргэжлийн байгууллагаас тогтоосон акт дүгнэлт, хууль хяналтын байгууллагын шийдвэр, хохирол барагдуулсныг нотлох баримт, сэргээн засварлаж ашиглахад шаардагдах эдийн засгийн тооцоо үндэслэл;

2.1.8 Эрх бүхий байгууллагаар хийлгэсэн хөрөнгийн үнэлгээ;

2.1.9.Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй номыг устгах талаар гаргасан холбогдох мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл;

2.1.10.Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй буу, галт зэвсэгийг хураах талаар Цагдаагийн байгууллагын албан ёсны зөвшөөрөл;

2.1.11. Түүх соёлын дурсгалт зүйлсийн талаарх аливаа шийдвэрийг гаргахад соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын санал;

2.1.12 Бусад шаардлагатай баримт, материал.

2.2. Үл хөдлөх хөрөнгийн хувьд энэхүү журмын 2.1-д зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ.

2.2.1. Үл хөдлөх хөрөнгө байрлаж буй газрын эзэмших (ашиглах) эрхийн гэрчилгээ, газар эзэмшүүлэх (ашиглуулах) гэрээ, кадастрын зургийн хуулбар;

2.2.2. Үл хөдлөх хөрөнгөд хийсэн их болон урсгал засварын зардал, тухайн эд хөрөнгөтэй холбоотой бусдын өмнө хүлээсэн хариуцлагын (зээл, өрийн барьцаа, баталгаа гэх мэт) болон ашиглалтын талаархи мэдээлэл;

2.2.3.Барилгын паспорт/хувийн хэргийн хуулбар, орчны тойм зураг, байгуулалтын /план/ болон гадна, дотор талын өнгөт фото зураг, инженерийн шугам сүлжээний техникийн зургийн хуулбар, бусад бичиг баримт.

2.3.Тээврийн хэрэгслийн хувьд энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ:

2.3.1.Тээврийн хэрэгслийн гэрчилгээ, техник ашиглалтын дэвтэр, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдол, зам

ашиглалтын төлбөр төлөгчийн гэрчилгээний хуулбар, холбогдох байгууллагаас гаргасан техникийн дүгнэлт

2.3.2. Техникийн үзүүлэлт, 4 талаас нь авсан өнгөт фото зураг;

2.3.3. Төслийн шугамаар ашиглагдаж байсан бол гаалийн татвар төлөлтийн талаархи мэдээлэл, холбогдох баримт;

2.3.4. Ашиглалтын сүүлийн 2 жилийн сэргээн босголтын зардлын дүн;

2.3.5. Ашиглалтад орсон он, балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл болон бусад мэдээллийг холбогдох байгууллагаас баталсан төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн “Тээврийн хэрэгслийн маягт”-ын дагуу.

2.4. Механизм, тоног төхөөрөмжийн хувьд энэ журмын 2.1, 2.3-д зааснаас гадна доорхи баримт, мэдээллийг ирүүлнэ:

2.4.1. Механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын паспортын хуулбар;

2.4.2. Барилга байгууламжид суурилагдсан бол энэ тухай мэдээлэл;

2.4.3. Бусад шаардлагатай материал.

2.5. Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн саналыг хүлээн авч хянан үзээд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчидээр хэлэлцүүлэн зохих шийдвэрийг гаргуулна.

ГУРАВ. ОРОН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД ЭД ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ

3.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгийг эрх бүхий байгууллагаас баталсан төсөв болон аймаг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаас баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдаж авах, үйлдвэрлэл, ажил үйлчилгээний үр дүнд бий болгох, эсхүл иргэн, хуулийн этгээдээс үнэ төлбөргүй шилжүүлж авах, түүнчлэн хандив, тусламж, бэлэглэл, эрх залгамжлах журмаар олж авна.

3.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга /захирал/ нь өөрийн чиг үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг гарган, зорилтын саналын хамт жил бүрийн 6 дугаар сарын 1-ний дотор аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлнэ.

3.3. Эд хөрөнгийн захиалга, жагсаалтад тоо хэмжээ, үнийн дүн /үнэ/, хүчин чадал, техникийн үзүүлэлт, бусад шаардлагатай тайлбар тодорхойлолтыг тусгана.

3.4. Орон нутгийн өмчийн газар нь захиалга, жагсаалтыг нягтлан шалгаж нэгтгэн Санхүү төрийн сангийн хэлтэс танилцуулан үнийн дээд хязгаар, эрэмбийн

саналын хамт аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж зохих шийдвэрийг гаргуулна.

3.5. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгө худалдан авах үнийн дээд хязгаарыг тогтоохдоо эрх бүхий байгууллагаас баталсан төсөв, төсөөлөл болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан эх үүсвэр, тээврийн хэрэгслийн тухайд тогтоосон тоо, төрлийг харгалзан үзнэ.

3.6 Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь шинээр хөрөнгө олж авахдаа аймгийн Орон нутгийн өмчийн газраас бичгээр зөвшөөрөл авна.

3.7. Хуулийн этгээд нь улсын болон орон нутгийн төсөв, тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд эх үүсвэр нь батлагдаагүй боловч ажлын зайлшгүй хэрэгцээ шаардлагаар үндсэн хөрөнгө худалдан авах тохиолдолд тодорхой үндэслэл, хөрөнгийн эх үүсвэрээ эрх бүхий байгуулагад тавьж шийдвэрлүүлсний үндсэн дээр Орон нутгийн өмчийн газраар уламжлуулан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд саналаа тавьж зохих зөвшөөрөл авна.

3.8. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь үйлдвэрлэл, ажил үйлчилгээний үр дүнд бий болсон эд хөрөнгө, хандив, банкны зээл, тусламж, бэлэглэл, эрх залгамжлах, нийгэмчилсэн, өр төлбөрт тооцон авсан, дайчилсан буюу хураан авах журмаар эд хөрөнгө олж авбал энэ тухай аймгийн Орон нутгийн өмчийн газарт мэдэгдэж зөвшөөрөл авна. /ОНӨГ нь аймгийн ИТХ-д танилцуулж зөвшөөрөл авна./

3.9. Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгөтэй холбогдуулан гарсан Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, болон эрх бүхий этгээдээс гаргасан төлөвлөгөө, төсөл шийдвэрийнхээ хувийг Орон нутгийн өмчийн газарт ирүүлж байна

3.10. Орон нутгийн өмчийн газар нь дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэсэн боловч худалдагдаагүй, эрх бүхий этгээд нь дуудлагын худалдаанд оролцоод үүргээ биелүүлээгүйгээс хөрөнгөө өөрийн болгох эрх нь үүсээгүй хөрөнгийг цаашид хэрхэн шийдвэрлүүлэх саналаа аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж орон нутгийн өмчид буцаан татаж бүртгэлд тусгуулна.

3.11. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагаа, өөрийн чиг үүрэгт өөрчлөлт орсон, хариуцах ажлын цар хүрээ өргөжсөн, багассан, бүтцийн өөрчлөлт хийснээс шалтгаалан үйлчилгээний автомашин нэмж авах, цөөрүүлэх зайлшгүй шаардлага гарвал автомашины тоо, төрөл тогтоосон шийдвэрт өөрчлөлт оруулах тухай саналаа аймгийн Орон нутгийн өмчийн газраар уламжлуулан шийдвэрлүүлнэ.

3.12. Орон нутгийн өмчит хуулийн этгээд автомашин шинээр худалдан авах санал ирүүлэхдээ илүүдэлтэй эсхүл ашиглалтын шаардлага хангахгүй автомашиныг худалдах, шилжүүлэх, актлах асуудлыг хамтад нь тавьж шийдвэрлүүлнэ.

ДӨРӨВ. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭД ХӨРӨНГИЙГ БҮРТГЭХ

4.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон энэ журмын 3.6, 3.8-д заасны дагуу зөвшөөрөл авсан үл хөдлөх хөрөнгө болон бусад хөрөнгийг хүлээн авч буй хуулийн этгээд нь тухайн хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан улсын комисс /Ажлын хэсэг/-ын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгийн нэр төрөл, үнийн задаргааг харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу үнэлж бүртгэнэ.

4.2. Гадаадын хандивлагч байгууллага, иргэд, хуулийн этгээдээс хэрэгжүүлсэн төсөл, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг тухайн иргэн, хуулийн этгээдийн албан ёсны зөвшөөрлийг авсаны үндсэн дээр үндсэн болон эргэлтийн хөрөнгөөр нь ангилан, ашиглах хугацаа, чанар байдлыг нь харгалзан ашигласан хугацааны элэгдэл, хорогдлын шимтгэлийг тооцож данс бүртгэлдээ тусгахыг хөрөнгө хүлээн авч буй хуулийн этгээд өөрөө хариуцна.

4.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд улсын болон орон нутгийн төвлөрсөн төсвөөс хөрөнгө оруулалт хийж үндсэн хөрөнгө бэлтгэсэн тохиолдолд хөрөнгийн үнэ өртөг, тоо хэмжээг тухайн хөрөнгийн санхүүжилтийг хийсэн төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн зөвшөөрлийг авч эзэмшигч байгууллага нь шууд данс бүртгэлдээ тусгана.

4.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын хандивлагч байгууллага, иргэд, хуулийн этгээдээс хэрэгжүүлсэн төсөл, зээл, тусламж, хандив, бусад эх үүсвэрээр бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй, маргаантай тохиолдолд асуудлаа Орон нутгийн өмчийн газарт тавьж шийдвэрлүүлнэ.

4.5. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр төрийн өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийг хүлээлгэн өгөх, Монгол Улсын Их Хурлын тогтоол болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолоор Төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжин ирсэн хөрөнгийг хүлээн авч, орон нутгийн өмчид бүртгэхдээ дараахь материалыг бүрдүүлсэн байна.

4.5.1. Улсын их хурал, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол шийдвэр, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр, уг шийдвэрт шилжүүлэх хөрөнгийн үнэ өртөг, тоо хэмжээ, нэр төрөл, байршил, чанар байдлыг тодорхой тусгасан байх;

4.5.2. Шилжүүлэн авах үндсэн хөрөнгийг хүлээн авч, данс бүртгэлдээ тусгах байгууллагад энэ талаар мэдэгдэж, зөвшөөрөл, дэмжлэг авсан байхаас гадна өмч эзэмшигч байгууллагын саналыг авсан байх.

ТАВ. ЭД ХӨРӨНГИЙГ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ

5.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга /захирал/ нь илүүдэлтэй буюу ашигладаггүй газар, эд хөрөнгийг шилжүүлэх тухай болон, бусад байгууллагын эзэмшилд байгаа газар, эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авах саналтай байгууллагын удирдлага, өмч эзэмшигч байгууллагаас албан ёсоор зөвшөөрөл авч, холбогдох материалыг энэ журмын дагуу бүрдүүлэн ирүүлж шийдвэрлүүлнэ.

5.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрт зааснаар хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулж, тайлан балансад хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг тусгана.

5.3. Орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т зааснаар шилжүүлж болно.

5.4. Үл хөдлөх хөрөнгө болон их хэмжээний хөдлөх үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тохиолдолд аймгийн орон нутгийн өмчийн газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулан хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулж болно.

5.5. Эд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдон гарах зардлыг шилжүүлж авсан байгууллага хариуцна.

ЗУРГАА. ЭД ХӨРӨНГИЙГ АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ

6.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хагас болон бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогын дүн, өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, саналыг үндэслэн хөрөнгө акталж данснаас хасах тухай саналаа энэ журамд заасан баримт материалын хамт аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж шийдвэрлүүлнэ.

6.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараахь тохиолдолд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр данснаас хасна:

6.2.1. Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ нөхсөн, эсхүл ашиглалтын хугацаа нь дуусаагүй боловч ашиглах явцад хэн нэгний буруутай үйлдлээс болж эвдэрч гэмтэн цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын дүгнэлт гаргуулан буруутай этгээдээр хохирлыг барагдуулсан тохиолдолд;

6.2.2. Техник, технологийн болон хэрэглээний хоцрогдолд орж, зайлшгүй шинэчлэх шаардлагатай болсон эд хөрөнгө;

6.2.3. Балансын үнээ бүрэн нөхөөгүй боловч байгалийн гэнэтийн аюул, техникийн осолд өртсөнөөс цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон эд хөрөнгө;

6.2.4. Ашиглалтын явцад эвдэрч гэмтсэнээс засвар шинэтгэл хийж ашиглахад эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгө.

6.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө актлах саналаа Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхдээ энэхүү журамд нийцүүлэхээс гадна дор дурдсан зүйлийг заавал тусган хүснэгтээр илэрхийлсэн байна:

6.3.1. Данснаас хасах эд хөрөнгийн нэр, тоо хэмжээ, данснаас хасах болсон шалтгаан, тодорхойлолт, хүсэлт;

6.3.2. Уг эд хөрөнгийг акталж устгах, эсвэл акталж сэлбэгээр ашиглах тухай санал;

6.3.3. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл, дүгнэлт;

6.3.4. Байгалийн гэнэтийн аюул, техникийн осол, гэмтэлд өртсөн эд хөрөнгийн шалтгааны тухай холбогдох байгууллагын акт дүгнэлт.

6.4. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид үндсэн хөрөнгийг данснаас хасах шийдвэр гаргахдаа дараахь хэлбэрээр шийдвэрлэнэ.

6.4.1. Эд хөрөнгийг худалдах;

6.4.2. Орон нутгийн өмчит бусад хуулийн этгээдэд шилжүүлэх;

6.4.3. Сэлбэг, материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах;

6.4.4. Шууд устгах;

6.4.5. Барилга байгууламжийн хувьд тухайн өөрийн эзэмшлийн газрыг цаашид ашиглах зориулалтын талаар чиглэл өгөх;

6.4.6. Газар дээрх болон газар доорхи барилга байгууламжийг буулгах, хог хаягдалыг цэвэрлэх, газрыг нөхөн сэргээх зардлыг тусгах, ашиглаж болох материалыг үнэ тогтоон орлогод авах;

6.5. Орон нутгийн өмчит хуулийн этгээдээс үндсэн хөрөнгийг акталж сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах, данснаас хасах шийдвэрийг өмч хамгаалах байнгын зөвлөлөөрөө хэлэлцэн шийдвэрлэж, гүйцэтгэлийг устгалын акт, эргэлтийн хөрөнгөд орлого болгосон тэмдэглэл, худалдсан тухай акт хэлбэрээр баталгаажуулан, гүйцэтгэлийн үр дүнг аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлнэ.

6.6. Сумдын төсөвт байгууллагуудад ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, барилга байгууламж, газар, худаг ус, уст цэг, услалтын систем, оюуны өмч биет бус хөрөнгө зэргийг актлахдаа журамд заасан баримтыг бүрдүүлсэн нөхцөлд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хүсэлтийг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид шийдвэр гаргана.

6.7. Сумдын төсөвт байгууллагуудад ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, ном, тоглоом, тавилга эд хогшил зэрэг хөрөнгийг худалдах, шилжүүлэх, актлах устгах эрхийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас албан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр Орон нутгийн өмчийн газар зөвшөөрөл олгож сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид эрх эдлэх бөгөөд худалдсан, актлах устгалтаас орох орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал энэхүү журмын заалтыг мөрдөн ажиллана.

ДОЛОО. БУСАД

7.1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрх мэдлийн хүрээнд хамаарах төсөвт байгууллагын хооронд үндсэн хөрөнгө шилжүүлэх асуудлыг тухайн төвлөрүүлэн захирагчийн хүсэлтийг үндэслэн аймгийн Орон нутгийн өмчийн газар нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд тавьж шийдвэрлүүлнэ.

7.2. Үндсэн хөрөнгийн үнэлгээний залруулга болон дахин үнэлгээг Сангийн яамны холбогдох шийдвэр, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу аймгийн Орон нутгийн өмчийн газраас албан бичгээр зөвшөөрөл авсаны үндсэн дээр санхүүгийн тайланд тусгана.

7.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийн элэгдлийн хугацаа, хэмжээг тогтоохдоо Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн баримтална.

7.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь эд хөрөнгийг харуул хамгаалалтаар хангах бөгөөд дутагдал, зөрчил гарсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

**НАЙМ. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД
ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ БҮРТГЭХ, ШИЛЖҮҮЛЭХ, ХУДАЛДАХ,
АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ШИЙДВЭРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТАЙЛАГНАХ**

8.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх шилжүүлэх, худалдах, акталж данснаас хасах, устгах талаар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс гарсан шийдвэрийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл хэрэгжүүлж, тухайн хуулийн этгээдийн дарга (захирал) хяналт тавина.

8.2. Эд хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулна.

8.3. Эд хөрөнгийг бүртгэх, шилжүүлэх, худалдах, актлах шийдвэрийг хэрэгжүүлж дуусах хүртэлх хугацаанд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих үүргийг тухайн хуулийн этгээдийн дарга (захирал) хариуцна.

8.4. Эд хөрөнгө олж авсан, бүртгэсэн, шилжүүлсэн, худалдсан, акталсан тухай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрийн биелэлтийг заасан хугацаанд ирүүлнэ.

8.5. Орон нутгийн өмчит хуулийн этгээд олж авсан, бүртгэсэн, шилжүүлсэн, худалдсан, акталсан эд хөрөнгийн хөдлөлийн нэгдсэн тайланг жил бүр эрх бүхий байгууллагаас баталсан төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн “Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн жилийн мэдээ” маягтын дагуу гаргаж аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлнэ.

ЕС. ХАРИУЦЛАГА

9.1. Энэ журмыг зөрчсөн буруутай этгээдэд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 82 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

9.2. Энэ журам болон эд хөрөнгө олж авах, балансаас балансад шилжүүлэх, худалдах, актлах, бүртгэхтэй холбогдон гарсан бусад хууль тогтоомж, журмыг зөрчсөнөөс Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд болон төсөвт учирсан хохирлыг буруутай этгээд хариуцна.